

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дүгэрийн Дорж	Дугаар	L061
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Халх гол сум
Төрсөн газар	Дорнод аймаг халх гол сум	Төрсөн он	1926
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тамсагийн хийд	Сүм хийдийн дугаар	ДОХГ 042
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагийн хийд

-Бид нэг судалгаан дээр тулгуурлаж яваа. Тэр судалгаанд Халх гол суманд Тамсагийн хийд гэж тэмдэглэгдсэн байна.

Тийм тэнд чинь л би байсан юм даа. Тэр чинь хуучин Халхын сүм гэж байсан юм. Халхын сүм гэдэг чинь одоо Буйрын хойд дээр Баргын нутагт нутаглаж байгаад тэгээд Тамсагт очсон байхгүй юу.

-Хэдэн оны үед тэгж очсон юм бол оо?

За тэр чинь одоо юу вэ дээ? Мэдэхгүй байна. Арван хэдэн онд юм уу, тийм л байж таарах нь дээ.

-Халхын сүмийг тийшээ очихоос өмнө Тамсагийн хийд гэж хуучин байсан уу?

Байгаагүй байх. Жаахан байсан болохоор сайн мэдэхгүй байна. Би 6 настай лам болж орсон болохоор мэдэхгүй байна шүү дээ. Үнэхээр мэдэхгүй байна. Аа би өөрийнхөө орсон хийдийг бол гайгүй мэднэ. Тамсаг булагийн урд дээр хуучин Халхын сүм гэж байсан. Одоо бол Тамсаг булагийн сүм гэж нэрлэгддэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тамсаг булагийн хийд хэр олон ламтай, хэдэн дугантай байсан бэ?

Өө тэр олон ламтай байсан. Тэр Тамсагийн хийд гэдэг лав 500, 600-аад орчим лам байсан.

-Таныг сууж байх үед шүү дээ?

Тийм. Учиргүй олон зуун гэр байсан.

-Хэдэн дугантай байсан бэ?

Багцаалахад нэг 9, 10 дуган байсан. Тэрэнд чинь одоо Чойр гэж байсан. Лхавх гэж байсан.Гол сүм гэж байсан.

Гол сүм гэж гол хурлаа хурдаг.

-Манба дацан байсан уу? Гэндэн тойн гэдэг хүн чинь Манбад хурдаг байсан уу?

Үгүй ээ. Тэр Лхавх дацан гэдэг юм. Тэр чинь дандаа уншлагатай лам нарын дацан байхгүй юу.

-Гол хурлын уншлага нь юу байсан юм бол доо?

Одоо мэдэхгүй дээ. Голын тэр Цогчэн гэдэгт байж байгаад уншлагаар нь ялгаад байдгийн билээ л дээ. Тэгэхээр Лхавх гэдэг дацанд л очсон юм даг. Тэнд багцаагаар бодоход 100-аад шахуу, 70, 80-аад лам нар байсан. Яг тэр дацанд л. Хоёр талаараа хуваагдаад суучихна. Хоёр талаараа мөртэй. Хоёр талаар нь 3,3 гудамтай. Дундуураа кридортой. Хойш урагшаа яваад байдаг. Хойноо зул хүжээ барьдаг, бурханаа тахидаг ийм байсан. Бага байсан болохоор үнэндээ мэдэхгүй байна. Надаас өөдтэй хүн байсан бол зээ гэгч мэдэж байх.

-Жүд, Ёга, Дүйнхор гэсэн дацангууд байсан уу?

Дүйнхор бол байсан. Одоо би чинь өөрөө 80 гарсан өвгөн. Үнэндээ юу гэж нэрлэдэг нэрээ олохгүй байна шүү дээ.

-Ёгын гүрэмний дацан байсан уу?

Үгүй үгүй тийм юм байгаагүй.

-Ганжуур, Ламрин дацан гэж байсан уу?

Байгаагүй. Харин Манба гэж байсан. За тэгээд гол сүмтэйгээ 5,6 дуган байсан юм шиг байна.

-Жодын хуралтай газар байсан уу?

Одоо мэдэхгүй юм. Байгаагүй байх аа.

-Хийдийн байсан газар маань яг хаана байсан бэ?

Тамсаг булагийн баруун биеэр тойроод яг урд нь. Тэндээс нэг 500 м байсан юм уу, үгүй юу. Бид явган ус зөөгөөд л гүйдэг байсан. Тамсагийн булаг гэдэг чинь хоёр гурван салаатай. Тэрний эрэг руу нь ороод 40-ийн бидон шиг юмаар ус зөөдөг байсан. Тэр лам нарын. Тийм л байсан юм даа.

-Хамбын хүрээ, Эрхэмсэг бэйсийн хүрээ гэж хаана байсан хийд вэ?

Тэрийг бол би үнэхээр мэдэхгүй.

-Эрхэмсэг бэйсийн хүрээ, Захын да бэйсийн хүрээ гэдэг ч байсан юм байна.

Тийм юм бол дуулдаж л байсан. Үнэндээ сонирхдоггүй байж. Тэр бол ухаандаа манайхан чинь Баян-Эрхтий, Баруун цагаан овоо, Дайван гээд омог, омогнууд нь дандаа өөр өөр. Тэр болгон дандаа тус тусдаа сүмтэй.

Чухам тэр нь юу гэсэн нэртэй хийд байсныг нь би мэдэхгүй. Хоёр том сүм байсан. 10 гаран 10 гаран багтай. Тэд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нар бол бүгдээрээ л хийдтэй байсан. Миний 5,6 хийд гэдэг чинь тэр. Тэр баруунтаа Матадын баруун хойд биед Зуухтад очиход 5 хийд дамжиггүй байсан. Их том үстай худаг байсан. Тэр худгаа тойроод хэсэг хэсгээрээ байсан. 3 жижигхэн хийд байсан. 2 нь мундаг том хийд байсан. Тэр нь Панжигнайлан гэдэг сүм байсан.

- Панжигнайлан гэж аль сүмээ хэлдэг байсан юм бэ?

Аль нь юм бол оо? Зүүн талынх нь голоо дагасан Буйр сүм гэж байсан. Буйр сүм гэж 10 хэдэн багтай. Тэрний л сүм байх гэж би боддог. Панжигнайлан гэж нэр нь дамжиггүй мөн.

-Тэр 5 сүмийг бусдыг нь юу гэж нэрлэдэг байсан бэ?

Тэгчилэн гэж байсан. Хоёрынх нь нэрийг мэдэхгүй байна. Харь омгийнх нь хошууны хийдийг мэдэхгүй байна. 5 хийд бий. Яах аргагүй байсан юм.

-Баян-Өлзийтийн хийд гэж ямар хийдээ хэлж байсан юм бэ?

Баян-Өлзийтийн хийд гэдэг чинь Тэгчилэн гэж байсан. Баян-Өлзий гэдэг чинь цомхон 2 баг 100 гаран өрхтэй. Тэр бол тусдаа нэг хийдтэй байсан.

-Тэр нь одоо хаагуур байрладаг байсан? Хулст гэдэг газар байсан уу?

Аа мэдэхгүй. Чухам Тамсаг булагийн урдтай байж байхдаа 2, 3 хийд байсан тэрэнд байсан юм уу мэдэхгүй. Өөр газар байж байгаад дамжаад нэгдсэн журмаар Зуухтад очсон юм уу? Чухам хаанаас нүүснийг би мэдэхгүй. Тэгэхдээ тэр 5 хийд бол тус тусдаа омог омгийн хийд байсан байх.

-Хулстын хийд гэж байна. Тэр маань Хулстайд, Чойнхордэгчилэн хийд гэдэг?

Хулстайд хийд байсан гэж сонссон. Хулстай Тамсаг булагаас 20-иод км зайтай. Тэрүүгээр цөгц мөгц, бурхан шашны эд зүйлс олддог гэж яригддаг.

-Утай уул гэдэг алийгаа хэлээд байгаа юм бэ? Тамсаг булагийн хийдээ Утай уулын хийд гэж нэрлэдэг байсан юм уу?

Тамсаг булаг гэдэг бол том булаг байдаг. Зүүн хойшоогоо урссан. Одоо тэр Халхын сүм байсны чинь Зүүн хойхнотой дууссан хоёр эхтэй. Тийм булаг байдаг. Тэрнээсээ хойшоо яваад яг одоо Тамсагийн дээр нь 6-р морьт дивиз гэж их том цэргийн анги байсан. Тэрний дэргэд дээр үеийн Утай Таван уул гэж байсан. Дээшээгээ бас нэлээн өндөр өө. 10 гаран 20иод шахуу метрийн өндөр. Дандаа л шороо овоолчихсон л юм шиг байдаг юм. Чухам тэр нь юуны ч булш байдаг юм. Дээр үеийн булш байсан байлгүй. Тийм эд байдаг юм. Тэрийг шүтэж байсан явдал бол сүүлийн хэдэн жил лав байгаагүй. Залуу зандан насны үед яаж байсныг мэдэхгүй.

-Хэрвээ энд хийд байсан бол таны хурж байсан Тамсаг булагийн хийдээс тусдаа хийд үү?

Тусдаа хийд. Тэр чинь хоорондоо 6,7 км-ийн зайтай байгаа юм. Тэгэхлээрээ тэр чинь яаж нийлж болох вэ дээ. Тамсагийн сүмээсээ зайтай л байж таараа.

-Сангийн далайн тэр хавьд ямар хийд байсан бэ?

Сангийн далайнхыг мэдэхгүй. Сангийн далайн замаар л баруунтшаа Матад дайраад хойшоогоо Эрдэнэцагаан гээд нүүж байсан даа. Хоёр гурав дахин нүүхдээ тэрүүгээр нүүж байсан юм.

-Таны хурж байсан Тамсаг булагийн хийдийн тухайд, ямар сахиустай байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Махагал бурхан гэж байсан. Их том суугаа хүний дайтай. Их том. Алтан өнгөтэй. Дотроо баримал л байсан байлгүй. Бодвол алтаар өнгөлчихсөн байсан байлгүй. Дээрээ овоодойтой байсан. Том лам нарыг дагаад мөргөж байлаа.

-Хийдийн мяндагтангуудын нэрийг санаж байна уу?

Гэндэн тойн гэдэг байсан. Миний сүүж байсан гол том сүм дээр болбол цорж гэдэг лам байсан. За тэгээд гол хуралд суудаг уншлагатай том лам нар бол байсан.

-Цогчэний унзад, гэсгүй нар нь хэн хэн байсан бэ?

Пэлжээ гэж унзад байсан.

-Өөр одоо онцлох юм юу байсан бэ? Цам гарч, Майдар эргэдэг байсан уу?

Өө цам жилд нэг гардаг байсан шүү. Цамыг би сүрч байх хугацаандаа жил болгон шахуу үзэж байсан шүү.

-Юуны цам голлож гардаг байсан бэ?

Тэр чинь одоо цам гарахдаа байна аа, юу гэдгийг дээ тэрнийг чинь. Сайн мэдэхгүй байна.

-Цам хэзээ гардаг байсан бэ?

Намар л 7,8 сарын үед гардаг байсан шиг санагдаж байна.

-Майдар эргэх нь хэдүйд болдог байсан бэ?

Тэр чинь бүх хүрээ хийдээ тойроод жилдээ нэг л болдог юм байна лээ л дээ. Сүйх мүйхтэй. Явган хүн түрээд дотор нь бурханаа залчихсан. Олон лам нар, нутгийн ард түмэн цувчихдаг. Тэгээд одоо бүх сүм хийдээ гороо маягаар тойроод явдаг байсан.

-Хайлан хурдаг байсан уу?

Хурж байсан.

-Дом тавьдаг байсан уу?

Домын лам гэж байсан. Нэлээн том том лам нар хайлан хурж, домд морддог байсан. Тэр үед чинь жаахан мэдэхгүй байсан. Гэхдээ би дом тавьж байхыг харсан. Би чинь хар болоод шашныг хаясан. Багадаа лам байсан гэхийн аргагүй. Бүгдийг хаясан. Одоо бол надад шашин шүтлэг энээ тэрээ юм байхгүй шүү дээ. Хааяа нэг зул барьчихна.

-Хийдийн дуганын барилгууд ямар барилга байсан бэ?

Тоосго ердөө байгаагүй. Дан модон барилга байсан. Одоо тэр Цогчэн гол дуган гэдэг чинь 8 билүү 6 баганатай билүү. Их л том олон зуун лам нар багтдаг байсан.

-Хэдэн давхар байсан бэ?

Ганцхан. Гэхдээ дээрээ томоо чиний сүүж байгаа хирээтэй алтан ганжиртай. Их сайхан. Холоос их сайхан харагддаг байсан юм.

-Суварга чодин байсан уу?

Суварга байгаагүй.

-Дуганууд нь гадуураа тойрсон хэрмэн хашаа байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тийм юм байгаагүй.

-Хийдийн хаагдах нураагдах үеийн тухай?

Хийд хаагдах үедээ Зуухтад байсан. Матадын баруун хойно.

-Сүмийн бурхан тахил, ном судар байшин барилга яасан бол оо?

Одоо мэдэхгүй. Тэр лам нарыг баригдангуут биднийг чинь аав , эжий нар минь аваад явчихсан. Тэгээд юу болсныг мэдэхгүй. Ер нь 10-аад хоног үргэлжлэн барьсан даа. Шөнө өдөргүй л машин давхиад л байсан. Тэр үед чинь машин гэж бараг байхгүй. Машиныг их сонирхдог байсан. Тэгээд нэг гурил будаа аччихсан юм шиг бэржээнхээр бүтээгээд хойноо их л том гүүзүүтэй машин байсан. Чухам гуч гэдэг нь ч байсан юм уу, ямар ч машин байсан юм лав л тэвштэй л машин байсан. Манаа цагдаа овоорсныг нь бууны бөгсөөр доош нь цохиод тэгээд аваад явж байхыг харсан. Лам нар баригдсанаас хойш 2, 3 унтсан уу, үгүй юу, тэгээд ердөө миний сууж байсан лам нар энэ тэр бол дороо л баригдсан.Манай тэр лам нэг дацангийн гэсгүй байсан юм.

-Хэн гэдэг хүн байсан юм бэ?

Жамц гэдэг байсан.

-Лам нарыг баригдах хүртэл хурал номын ажиллагаа хэвийн явагдаж байсан уу?

Хэвийн явагдаж байсан. Гэхдээ эхлээд лам нарт татвар ногдсон шүү. Оймгүй их татвар ногдоод хэрэв татвараа төлж чадахгүй бол гэж хугацаа тогтоож өгөөд төлж чадахгүй бол Хүрээнээс цааш нүүлгэнэ гэнэ гэж багачуулын чихээр тийм юм сонсогдож байсан. Тэгээд бариад эхэлсэн.